

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-12-15

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 12 дугаар сарын 23-ний “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийт байгууллагууд
2.	2026 оны төсөв батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулалтын ажлуудын эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба
3.	2026 оны эхний шуурхай зөвлөгөөн дээр улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын талаар танилцуулах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба
4.	Тендер шалгаруулалтыг 4 болон түүнээс дээш удаа зохион байгуулахад оролцогчгүй, амжилтгүй болсон төсөл, арга хэмжээний талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба
5.	Төсвийн орлого тасалдсантай холбогдуулан хэмнэлтийн горимыг чанд мөрдөж, үлдсэн хугацаанд орлого бүрдүүлэх ажлыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийт байгууллагууд
6.	Баяр, амралтын өдрүүдэд эргүүл, жижүүр томилон ажиллуулж, инженер хангамжийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, бэлэн байдлыг хангаж ажиллах.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс Онцгой байдлын хэлтэс, дэд бүтцийн байгууллагууд
7.	Нийтийг хамарсан баярын арга хэмжээний үеийн хэв журмыг сахиулах, бэлэн байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтэс

8.	Гамшиг осол болон гал түймэрийн аюулгүй байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах.	Онцгой байдлын хэлтэс
9.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүгнэлт хийж, холбогдох байгууллагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлэх.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийт байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10.	2026 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын тендер зарлах, бэлтгэлийг хангах	Худалдан авах ажиллагааны алба
11.	Баяр, амралтын өдрүүдэд ажиллах дүүргийн хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарь гарган батлуулах	Дүүргийн менежер, Онцгой байдлын хэлтэс
12.	“Багахангай үдэш-2025” арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах	Ажлын хэсэг, Нийгмийн хөгжлийн хэлтэс
13.	“Шинэ оны анхны нар угтах” ёслолын арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах	Ажлын хэсэг, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
14.	Хороодын хотхонуудын тохижилтын ажлуудыг эрчимжүүлэх, дуусгах	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, 1.2-р хороо
15.	2025 онд зохион байгуулах, төлөвлөгдсөн ажлуудыг дуусгах, 2026 оны байгууллагын төлөвлөгөөний төслийг боловсруулах	Нийт байгууллагууд
16.	Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, нийт байгууллагууд

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ